БАТЛАВ
ЕРӨӨ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б. СЭРГЭЛЭН

2023 оны 12 дугаар сарын 19

# ОЙН ТҮЙМРЭЭС ХАМГААЛАХ ХАЛЗ ЗУРВАС БАЙГУУЛАХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Ажил гүйцэтгэх талбай: Ерөө сумын ойн сангийн талбайд нийт 25,85 га талбайд ойн түймрээс хамгаалах халз зурвас байгуулах ажлыг хэрэгжүүлнэ.

I багц 25,85 га-8013500 төгрөг

1 га талбайд ойн түймрээс хамгаалах халз зурвас байгуулах ажил нь 310000 төгрөг нийт 8013500 төгрөгөөр байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлнэ.

Тендэрт оролцогч нь дор дурьдсан шаардлагыг хангасан төсөл боловсруулна.

<table>
<tr><td>ОЙН ТҮЙМРЭЭС ХАМГААЛАХ ХАЛЗ ЗУРВАС БАЙГУУЛАХ АЖЛЫН АГУУЛЛАГА, ҮЕ ШАТУУД</td><td>Сэлэнгэ аймгийн Ерөө суманд 25,85 га ойн түймрээс хамгаалах халз зурвас байгуулах ажлыг зохион байгуулна.<br><br>Тус ажил нь бэлтгэл, ойн түймрээс, зөрчил, гологдол арилгах, тайлан боловсруулах, тайланг хэлэлцүүлэн хүлээлгэн өгөх гэсэн үе шатуудтай байна.</td></tr>
<tr><td>БЭЛТГЭЛ АЖИЛ</td><td>1. Халз зурвас болон харлуулсан зурвасыг байгуулахад шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг бэлтгэх<br>2. Халз зурвас байгуулах технологийн картыг боловсруулж захиалагчаар батлуулах<br>3. Зурвасын талбайн хилийг тогтоож, зураглал гаргах, хилийн шонг хийж талбайг тусгаарлах<br>4. Халз зурвасыг байгуулах талбай дахь эсвөр насны модыг шилжүүлэн тарих бэлтгэл ажлыг хангах, шилжүүлэн тарих<br>5. Халз зурвасын талбай дахь модыг огтлох, хожуулыг зайлуулах бригадыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулна. Үүнд<br>➢ Бригадын дарга – 1<br>➢ Хөрөөчин-1<br>➢ Туслах хөрөөчин-1<br>➢ Тракторын оператор-1<br>➢ Оосорлогч-1<br>➢ Ачигч-4<br>➢ Жолооч-2<br>6. Зурвас байгуулах чиглэлүүдийг тогтоож цагаалах зам, ачих талбарыг бэлтгэх<br>7. Тээврийн машины зам гаргах</td></tr>
<tr><td>ТЕХНОЛОГИ АЖИЛБАРЫН ХҮРЭЭНД ХИЙХ БЭЛТГЭЛ</td><td>
<table>
<tr><th rowspan="2">№</th><th rowspan="2">Халз зурвас байгуулах газрын нэр</th><th rowspan="2">Хэсэглэлийн дугаар</th><th rowspan="2">Ялгарлын дугаар</th><th colspan="2">Халз зурвасын хэмжээ /м/</th></tr>
<tr><th>Урт</th><th>Өргөн</th></tr>
<tr><td>1</td><td>Зүүн сэнстэй</td><td>9, 10, 12, 14, 15, 16</td><td>-</td><td>17100</td><td>15</td></tr>
</table>
</td></tr>
</table>

| | |
|---|---|
| | ➢ Хөрсний гадаргуу дээрх шатах материалыг зайлуулна.<br>➢ Халз зурвас гаргах талбайд өртөх модны хэмжээг тооцож, ойн нөөц ашигласны төлбөрийг төлж мод бэлтгэх эрхийн бичиг авна. |
| **ТАЙЛАН БОЛОВСРУУЛАЛТЫН АЖИЛ** | Халз зурвас байгуулах ажлын тайланг захиалагчид 2 хувь ирүүлнэ Тайлан дор дурьдсан хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд<br>1. Халз зурвас байгуулах талбайн зураг 1:50000 масштабтай хийж ирүүлэх<br>2. Халз зурвасыг байгуулах ажлын гүйцэтгэлийн тайлан, фото зураг<br>3. Халз зурвасыг байгуулах талбайн ой зохион байгуулалтын зурагт буулгаж ирүүлэх<br>Зураг боловсруулалтын ажлыг Засгийн газрын 2009 оны 1-р сарын 28-ны өдрийн 25-р тогтоолын дагуу олон улсын WGS_1984_UTM_Zone_48N систем дээр зураглал гаргана.<br>Ажлын тайлан болон зургийн Shp файлуудыг цахим хэлбэрээр эсвэл /CD, DVD/ хувь ирүүлнэ. |
| **ХАЛЗ ЗУРВАС БАЙГУУЛАХ АЖИЛД ТАВИГДАХ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА** | 1. Цахилгаан хөрөө<br>2. Анжис ПКЛ-70А, ПКЛ-70Д эсвэл түүнтэй дүйцэх агрегат<br>3. Хөмрүүлэгчтэй ПЛ-1-1 анжис эсвэл түүнтэй дүйцэх агрегат<br>4. Ерөнхий зориулалтын анжис ПЛН 3-35, ПЛН 4-35 ПЛН 8-35 эсвэл түүнтэй дүйцэх агрегат<br>5. Мод тээврийн автомашин ЗИЛ-131, УРАЛ-675, КАМАЗ болон эдгээртэй дүйцэхүйц бартаа туулах чадвартай ачааны автомашин |
| **МЭРГЭШСЭН ИНЖЕНЕР ТЕХНИКИЙН АЖИЛЧДАД ТАВИГДАХ ШААРДЛАГА** | Халз зурвасыг байгуулахад шаардлагатай ойн аж ахуйн ойн инженер, техникийн болон улирлын ажилтнууд нь доорх шаардлагыг хангасан байна. Үүнд<br>➢ Ерөнхий инженер нь ойн аж ахуйн болон ойн инженер мэргэжилтэй. Ойн түймрээс хамгаалах халз зурвас байгуулах ажил буюу гэрээгээр заасан ажилтай төрөл, үнийн дүнгээрээ ижил төстэй ажил гүйцэтгэсэн 3 жилийн туршлагатай байх, түүний дотор гэрээ бие даан хариуцаж ажилласан 2 хүртэл жилийн туршлагатай байх<br>➢ Инженер техникийн ажилтан нь ойн инженер мэргэжилтэй. Ойн түймрээс хамгаалах халз зурвас байгуулах ажил буюу гэрээгээр заасан ажилтай төрөл, үнийн дүнгээрээ ижил төстэй ажил гүйцэтгэсэн 2 жилийн туршлагатай байх. Халз зурвасыг байгуулахад шаардлагатай техник хэрэгсэлийн ашиглалт, үйлчилгээний ажлыг бие даан гүйцэтгэх мэргэшсэн чадвартай байх<br>➢ Улирлын ажилчид нь өөрийн хариуцсан техник, хэрэгсэлийг ашиглах чадвартай, мэргэжлийн үнэмлэх болон зэрэгтэй байх, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны мэдлэг чадвартай байх гэнэтийн ослийн даатгал хийлгэсэн байх.<br>➢ Ойн түймрээс хамгаалах халз зурвасыг байгуулах ажлыг зохион байгуулахад шаардлагатай туслах ажилчид /тогооч, жолооч/ гэх мэт байх |

Зураг төслийн жагсаалт /тендерт оролцогч ирүүлэх/

| д/д | Зураг төслийн нэр | Агуулга |
|---|---|---|

| | | |
|---|---|---|
| 1 | Ойн түймрээс хамгаалах халз зурвас хийх ажил явуулах талбайн зураг | Ойн түймрээс хамгаалах халз зурвас байгуулах ажил гүйцэтгэх хугацааг харуулсан байх |
| 2 | Ойн түймраас хамгаалах халз зурвас байгуулах ажилд ашиглах багажийн зураг | Багажийн маркийг бүрэн гүйцэд харуулсан байх |
| 3 | Ойн түймраас хамгаалах халз зурвас байгуулах ажилд ашиглах автомашинуудын зураг | Ажилд ашиглах машинуудын зургийг тус бүрд нь харуулах |
| 4 | Ойн түймраас хамгаалах халз зурвас байгуулах ажилд ажиллах гар багаж, тоног төхөөрөмжийн зураг | Тоо хэмжээг бүрэн харуулсан байх |

## ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

| д/д | Ажлын нэр, тодорхойлолт | Тоо, хэмжээ | Нийлүүлэх хуваарь |
|---|---|---|---|
| 1 | Бэлтгэл ажил | 25,85 га | 2024.05.10-ны дотор |
| 2 | Ойн түймрээс хамгаалах халз зурвас хийх | 25,85 га | 2024.06.10-с 2024.09.20 хүртэл |
| 3 | Талбайг хүлээлгэн өгөх | 25,85 га | 2024.10.05-ны дотор |
| 4 | Зөрчил, гологдол арилгах | 25,85 га | 2024.10.10-ны дотор |
| 5 | Тайлан боловсруулах | 25,85 га | 2024.11.01-ний дотор |
| 6 | Тайланг хэлэлцүүлэн хүлээлгэн өгөх | 1 удаа | 2024.11.25-ны дотор |

## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН ОЙН ТҮЙМРЭЭС ХАМГААЛАХ ХАЛЖ ЗУРВАС БАЙГУУЛАХ АЖИЛ

Хавсралт

| д/д | Сумын нэр | Ойн түймрээс хамгаалах халз зурвас байгуулах ажил гүйцэтгэх | | | ОЗБ хийсэн огноо | Газрын төрөл |
|---|---|---|---|---|---|---|
| | | Талбай, га | Газрын нэр | Хэсэглэл | | |
| **Сэлэнгэ аймаг Ерөө сум** | | | | | | |
| **1** | Ерөө | 25,85 | Зүүн сэнстэй | 9, 10, 12, 14, 15, 16 | 2017 | Сумын хил /сум дамнасан түймрийг хязгаарлах |
| | **ДҮН** | **25,85** | - | | - | - |

## ОЙН ТҮЙМРЭЭС ХАМГААЛАХ ХАЛЗ ЗУРВАС АЖЛЫН ТЕХНОЛОГИЙН ДАРААЛАЛ

| № | Хийх ажилбаруудын дараалал | Хэмжих нэгж |
|---|---|---|
| 1 | 2 | 3 |
| **1.1** | Ойн түймрээс хамгаалах халз зурвас байгуулах талбайг сонгох | га |
| **1.2** | Ойн түймрээс хамгаалах халз зурвас байгуулах талбайг тусгаарлуулах | га |
| **1.3** | Ойн түймрээс хамгаалах халз зурвас байгуулах | га |